

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ТЗУХ-ИЙН ТҮНТ-ИЙН  
2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 09-16 -НЫ  
ӨДРҮҮДЭД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭ

2023 оны 06 дугаар сарын 08

Хэрлэн сум

Өргөдөл гомдол санал хүсэлтийн мэдээлэл: Иргэдээс 705631111 утсанд 19 дуудлага ирсэн. Төрийн байгууллагын үйлчилгээтэй холбоотой 4 өргөдөл хүлээн авч, шийдвэрлэлтийн шатандаа судлагдаж байна. Утгаар нь авч үзвэл: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт эмчийн ажил хийхэд ачаалал ихтэй байна, хүнсний ногоо тариалдаг газрын ойролцоо гахай тэжээж орчныг бохирдуулж байгаад хяналт тавих хэрэгтэй байна, А-57-р байранд цэвэрлэгээ муу, гэрэлтүүлэг байхгүй, орчин бохир байна.

Засгийн газрын 1111 төвд Манай аймагт хувиарлагдсан өргөдлөөс 10 өргөдөл хариу өгөгдөөгүй, шийдвэрлэлтийн шатандаа явагдаж байна. Үүнд: Газрын өмчлөл, өвөлжөө хаваржааны газраас хөөгдсөн, нийтийн эзэмшлийн талбайг зөвшөөрөлгүй сунгаж өргөтгөл барьсан зэрэг газрын асуудлаар хандсан 7, автомашины торгууль давхардуулж төлүүлсэн гэсэн утгатай нийт өргөдөл хариу өгөгдөөгүй. ХОХБТХэлтэст цохогдон ГХБХБГазар, Автотээврийн төвд шилжүүлэгдсэн байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой 1, Группэд хамрагдахад хугацааг 2 жил сунгах өргөдөл 1, нийт 2 өргөдөл НБХэлтэст цохогдон судлагдаж байгаа.

Цохогдсон өргөдлийн шийдвэрлэлтийн явц ямар шатандаа явагдаж байгаа талаар холбогдох албан тушаалтнуудад утсаар ярьж асуусан ба шууд хариу өгөх боломжгүй судлагдаж байгаа, хариу өгнө гэсэн хариуг өгсөн.

705631111 төвд "Нээлттэй Хэнтий аймаг" мэдээлэл авах хүсэлт гаргаж 4 иргэн хандсан. Үүнд: Зөгийн үүр хөтөлбөрт хэрхэн хандах вэ? гэсэн асуулга ирсэн.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд 1713 нийт иргэн үйлчлүүлснээс. Өөртөө үйлчлэх танхимаар 198, утсаар 249, цахим 17, биечлэн 1249 иргэн үйлчлүүлснээс. Улсын бүртгэлээр 182, Нийгмийн даатгалаар 115, Хөдөлмөр халамжийн үйлчилгээгээр 201, Газрын харилцаагаар 406, Архивын үйлчилгээгээр 3 хадгаламжийн нэгж 635 хуудас баримтанд тодорхойлон бичилт хийж 3 иргэнд зөвлөгөө өгсөн. Хууль зүйн зөвлөгөөгөөр 7, Хурдан ТҮЦгээр 62, Нотариатын үйлчилгээгээр 90, e-mongolia сурталчилах цэгээр 81, E-khutuch.mn булангаар 1, Төрийн банк 101, иргэн үйлчлүүлсэн.

Үнэлгээний төхөөрөмжинд нийт 363 үнэлгээ өгөгдсөнөөс: Маш сайн 354 сайн 7, дунд 2, үнэлгээ өгөгдсөн байна.